

СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.06.02. №66 (66)

ҮЙЛ ЯВДАЛ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 326 ДУГААР АНГИД



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр энэ сарын 28-ны өдөр Цэргийн гавьяаны одонт Зэвсэгт хүчний 326 дугаар ангид ажиллалаа. Батлан хамгаалахын сайдыг Сонгино цэргийн хүрээний Хүндэт харуул ёслол төгөлдөр угтан авсны дараа ангийн танилцуулгыг сонсож, сүүлийн жилүүдэд хийж хэрэгжүүлсэн томоохон ажил, цэргийн сургалт бэлтгэл, штабын бэлтгэлжилт болон тулгамдаж буй асуудлыг сонсож, ангийн 2021-2030 он хүртэлх "Алсын хараа"-ны баримт бичигтэй танилцсан юм. Батлан хамгаалахын сайдыг дагалдаж, БХЯ-ны СБТГ-ын дарга, хурандаа С.Ганбямба, ТЗУГ-ын дарга, хурандаа Ч.Гандирваа, Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлагч,

хошууч генерал Б.Амгаланбаатар нар ажилласан юм.

Энэ үеэр цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн байраар орж алба хаах хугацаандаа суралцаж буй англи, солонгос хэл, шатар, даам, гитарын дугуйлангийн явцтай танилцаж, дайчдын ар гэрийн төлөөлөлтэй цахимаар холбогдож, санал хүсэлтийг нь сонслоо.

Мөн Батлан хамгаалахын сайд ангийн бие бүрэлдэхүүнтэй Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчний шинэчлэл, хийж хэрэгжүүлж буй ажлынхаа талаар мэдээлэл хүргэж, хугацаат цэргийн алба хаагчдын бэлтгэсэн урлагийн тоглолтыг үзэж сонирхлоо.

ДЭСЛЭГЧ ГЕНЕРАЛ Ч.ПҮРЭВДОРЖИЙН НЭРЭМЖИТ БОЛЛОО



Зэвсэгт хүчний 353 дугаар анги төр, цэргийн нэрт зүтгэлтэн, дэслэгч генерал Ч.Пүрэвдоржийн нэрэмжит боллоо

Ёслолын ажиллагаанд Агаарын цэргийн командлагч, хошууч генерал О.Энхбаяр, Агаарын цэргийн командлалын захиргааны удирдлагын хэлтсийн дарга, хурандаа Э.Баярсайхан, дэслэгч генерал Ц.Пүрэвдорж агсны зээ охин М.Мөнхцэцэг болон албаны бусад хүмүүс оролцлоо. Агаарын цэргийн командлагч, хошууч генерал О.Энхбаяр "БНМАУ-ын БХЯ-ны I орлогч сайд, Ардын армийн Жанжин штабын дарга асан, дэслэгч генерал Ч.Пүрэвдорж нь Ардын армийн шинэ төрлийн цэрэг болох улсыг агаарын довтолгооноос хамгаалах цэргийн тулгийн чулууг тавилцсан

үндэслэгчдийн нэг билээ. 1964 онд Монгол Улсад агаарын довтолгооноос хамгаалах цэргийн анхны зенитийн пуужингийн дивизион байгуулагдахад захирагчаар нь Ч.Пүрэвдорж томилогдон ажилласан нь одоогийн Зэвсэгт хүчний 353 дугаар анги юм. Тэрбээр агаарын цэргийн үндэс суурийг тавилцаж, хөгжил, цэцэглэлтэд нь оролцож явсан гавьяатай. Иймд тус ангийг түүний нэрэмжит болгох нь зүй ёсны хэрэг гэж бодож байна" гэв. Дараа нь тус ангийг дэслэгч генерал Ч.Пүрэвдоржийн нэрэмжит болгох тухай Батлан хамгаалахын сайдын тушаал, Нийслэлийн иргэдийн хурлын тогтоолыг ангийн захирагчид гардуулан өглөө. Мөн энэ үеэр түүний нэрэмжит өрөөг шинээр байгуулснаа хүрэлцэн ирсэн хүндэт зочдод сонирхууллаа.

ОЛОН УЛСЫН ХҮҮХДИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ӨДРИЙГ ТЭМДЭГЛЭЛЭЭ



Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад явагдаж буй НҮБ-ын мандаттай UNMISS энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэж байгаа Монгол Улсын Зэвсэгт хүчний Х ээлжийн мото буудлагын батальоны бие бүрэлдэхүүн "Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр"-өөр Бентью суурин дахь Дотоодын дүрвэгсдийн хуарангийн хүүхэд багачуудын дунд баярын арга хэмжээг "Хубилай" баазын байрлалд зохион байгууллаа.

Энэхүү өдрийг манай энхийг сахиулагчид НҮБ-ын хамгаалалттай Дотоодын дүрвэгсдийн хуарангийн хүүхэд, багачуудыг багахан ч болтугай баярлуулах, дайн самуун, байгалийн гамшиг, өлсгөлөнгийн зовлонг түр атугай мартуулж, тэдэнд баяр хөөр, аз жаргал

түгээх зорилгоор зохион байгуулсан юм.

Баярын арга хэмжээнд Дотоодын дүрвэгсдийн хуарангийн 8 сургуулийн 150 гаруй хүүхдүүд оролцсон бөгөөд тэдний дунд бүжгийн тэмцээн зохион байгуулж, урлагийн тоглолт, өдрийн амтат хоол, хүүхэд бүрт гарын бэлэг, тоглоом, хичээлийн хэрэгслийг бэлэглэж, дурсгалын зургаа татуулан нэгэн өдрийг хүүхдийн баяр хөөр, инээдээр дүүрэн тэмдэглэн өнгөрүүлээ.

Түүнчлэн хүрэлцэн ирсэн хүүхэд багачууд бидний зохион байгуулсан арга хэмжээг талархан хүлээн авч, өөрсдийн бэлтгэсэн урлагийн тоглолтуудыг үзүүлсэн нь эх орон, энхрий үрсээ санасан энхийг сахиулагчдын маань сэтгэлийг ихэд хөдөлгөж байлаа.

Ахлах дэслэгч Г.ЦЭРЭННАДМИД

ЗОХИОН БИЧЛЭГИЙН УРАЛДААНАА ДҮГНЭЛЭЭ

Олон улсын энхийг сахиулагчдын өдрийг тохиолдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабаас Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд "Энхийг сахиулагчдын алдар гавьяаг таниулах, эх оронч үзлийг төлөвшүүлэх" зорилгоор зохион байгуулсан зохион бичлэгийн уралдааныг олон улсын "Хүүхдийн эрхийг хамгаалах

өдөр"-ийн өмнө дүгнэж, шагнал гардуулах арга хэмжээг зохион байгуулав.

Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабындарга, хурандаа Ц.Анхбаяр зохион бичлэгийн уралдаанд идэвхтэй оролцсон сурагчдад хандан "Та бүхэн энхийг сахиулагчдын талаарх мэдлэгээ нэмэгдүүлэхийн зэрэгцээ баримтат кино үзэж, өөрсдөө шүлэг хүртэл зохиосон нь сайшаалтай байлаа" гэж

онцлоод тэргүүн байранд шалгарсан Баянгол дүүргийн 20 дугаар сургуулийн 11"А" ангийн сурагч О.Батмэнд, дэд байрны шагналтан Чингэлтэй дүүргийн 117-р сургуулийн 10"А" ангийн сурагч Х.Номинжин, гутгаар байранд шалгарсан Баянзүрх дүүргийн 102 дугаар сургуулийн 10"Г" ангийн сурагч Б.Мөнхзул нарт талархал, мөнгөн шагналыг гардууллаа.

Ахлах дэслэгч Б.БАТЦЭЦЭГ



МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

59.229

ЭДГЭРСЭН

50.763

НАС БАРСАН

283/14

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

2591 (34)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

267

ЭДГЭРСЭН

2288

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 170,051,718

Эдгэрсэн

Нийт: 147,024,06

Нас барсан

Нийт: 3,540,437

ЕРӨНХИЙ ҮЗҮҮЛЭЛТ

БАТЛАГДСАН ТОХИОЛДОЛ

СҮҮЛИЙН 24 ЦАГТ **790** НИЙТ **59,229**

ЭДГЭРСЭН СҮҮЛИЙН 24 ЦАГТ **327** НИЙТ **50,763**

НАС БАРАЛТ /БУСАД ШАЛТГААНТ/ **7** НИЙТ **283/14**

2021.06.01
11:00 ЦАХИМ БАЙРЛААР

ХАРИУЦАГ
ДАВНА

ҮЙЛ ЯВДАЛ

“ЗЭВСЭГТ ХҮЧИН-100” ГАР ЗУРГИЙН УРАЛДААНЫ ШИЛДЭГ БҮТЭЭЛҮҮДИЙН ЦОМОГ ГАРЛАА

Зэвсэгт хүчний Жанжин штабаас “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан оюутан, сурагчдын монгол цэргийн тухай өгүүлэх шилдэг гар зургийн цомгийг уншигчдын гарт хүргэхэд бэлэн болголоо.

Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штабаас орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан Батлан хамгаалах яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, аймаг, нийслэл, дүүргүүдийн Цэргийн штабуудтай хамтран оюутан, сурагчдын дунд “Зэвсэгт хүчин-100” жил гар зургийн уралдааныг өнгөрсөн 3 дугаар сард зохион байгуулсан билээ. Монгол Улсын Зэвсэгт хүчний түүх, дайчин замнал, баатарлаг үйлсийг судалж, танин мэдэх хүсэл эрмэлзлэлийг оюутан, сурагчдад төрүүлэх, тэдний авьяас, чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор улс орон даяар зохион байгуулсан уралдаанд 800 гаруй хүүхэд багачууд бүтээлээ ирүүлсэн томоохон арга хэмжээ болж чадсан юм.

Тэгвэл 800 гаруй бүтээлийн шилдэг 120 гар



зургийг багтаасан “Зэвсэгт хүчин-100” номыг Зэвсэгт хүчний Жанжин штабаас Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран бүтээж, уншигчдад хүргэхэд бэлэн болгов. Энэхүү номыг бүтээл нь орсон ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах болон их, дээд сургууль, коллежийн 120 гар зургийн эздэд харьяа аймаг,

нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб болон Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраар дамжуулан олгох юм. Мөн цаашдаа ЗХЖШ-аас иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, хүүхэд, залуус цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэхэд дайн тулаан, цэрэг дайчид, тэдний байгуулсан гавьяаг өөрсдийн оюун сэтгэмжээр сийрүүлсэн гар зургийн уралдааны шилдэг бүтээлүүдийн цомгийг ашиглана.

“ХҮҮХДИЙН ЕРТӨНЦ-2021” УРАЛДААНЫГ АМЖИЛТАЙ ЗОХИОН ЯВУУЛЛАА

Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Ангийн соёл хүмүүжлийн албанаас санаачлан Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан “ХҮҮХДИЙН ЕРТӨНЦ-2021” уралдааныг амжилттай зохион явууллаа. Тус уралдаан нь хүүхдийн дүрслэх сэтгэхүй, зурсан зураг, уран сэтгэмжийг өөрсдийн үзэл бодлоороо илэрхийлэх, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд оршиж байгаа юм.

Уралдаан гурван насны ангиллаар зохиогдсон ба “Аз жаргалтай инээмсэглэл” фото зургийн уралдаан 1-5 нас, “Хүүхэд бүр уран бүтээлч” наамлын уралдаан 6-9 нас, “Миний мөрөөдөл” гар зургийн уралдаан 10-12 насны ангиллаар ирсэн бүтээлүүдийг шалгаруулж, шагналыг нь ангийн захирагч хурандаа Ж.Өсөхбаяр гардуулан өгсөн юм.

Үүнд, 1-5 насны ангилалд Тэргүүн байрт Ч.Аригунтөгс, дэд байрт Т.Баттушиг, гутгаар байрт Д.Билгүүн, тусгай байрыг Г.Тэнүүнбаяр нар эзэлсэн бол 6-9 насны ангилалд Тэргүүн байрт М.Гоомарал, дэд байрт Б.Нарансолонго, гутгаар байрт



И.Ирэхнаран, тусгай байрыг Б.Төрболд, 10-12 насны ангилалд Тэргүүн байрыг Л.Нарангоо нар тус тус шагналт байруудад шалгарлаа.

Дэслэгч Г.НАНДИНЧИМЭГ

ОРОН НУТАГТ ЦЭНХЭР ДУУЛГАТНУУДАА СУРТАЛЧЛАВ



Зэвсэгт хүчний 186 дугаар анги

“Олон улсын энхийн сахиулагчид”-ын өдрийг тохиолдуулан Орхон аймгийн Номин телевизтэй хамтран “Энхийг сахиулах ажиллагааны тал”-аар нэвтрүүлэг бэлтгэн орон нутгийн ард иргэд хүүхэд залуучуудад Зэвсэгт хүчин, анги байгууллагынхаа үйл ажиллагааг сурталчиллаа. Нэвтрүүлэгт Танкийн ротын Салааны захирагч дэслэгч А.Галмандах, Танкийн ротын ахлагч, сургагч ахлагч Ц.Баярцогт нар оролцлоо.

“ХОГГҮЙ ЗАВХАН” АЯНД УРИАЛАВ

Зэвсэгт хүчний 325 дугаар анги

“Covid-19” цар тахлаас урьдчилан сэргийлэх хөл хорионы дэглэмийг хэвийн байдалд шилжүүлсэнтэй холбогдуулан Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн хорооны төвийн офицер, ахлагч нар Улиастай сумын Богдын гол дагуух 1км орчим газрын хогийг цэвэрлэж орон нутгийн байгууллага, ард иргэдийг байгаль орчноо цэвэрлэх “Хоггүй Завхан” аянд уриалж байгаагаа Завхан аймгийн нэгдсэн мэдээллийн сайтад нийтэллээ.



* Энэ сарын цэргийн тангараг давтах ёслолын ажиллагааны үеэр цэргийн жинхэнэ алба хаасны тэтгэвэрт гарсан ангийн ахлагч бэлтгэл тэргүүн ахлагч О.Бурэнбат, Авто техникийн салааны

шалгах байрны дарга бэлтгэл ахлах ахлагч Ц.Эгийнбаатар, Холбоо салааны тасгийн захирагч бэлтгэл ахлах ахлагч Ц.Сугармаа гэсэн бүрэлдэхүүн ангийн байлдааны тулт хүндэтгэл үзүүлэх ёслолын

ажиллагааг зохион байгуулав. Мөн эдгээр ахмад дайчдыг анги байгууллагадаа үр бүтээлтэй ажилссаныг үнэлж ангийн захирагчийн тушаалаар Байлдааны дэлгээ тугийн өмнө зургийн авч алдаршууллаа.

БАЙЛДААНЫ ТУГАНД ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭВ



Н.Очирбат, үе үеийн ангийн захирагч, анхны нисгэгч, механикч, техникч нарын төлөөлөл ахмад дайчид оролцлоо.

Энэ үеэр ахмад дайчин М.Мягмаржавыг “Алтан гадас” одонгоор, Д.Оюунцэцэгийг цэргийн гавьяаны одонгоор, Д.Оюун, Б.Аяналганыг хөдөлмөрийн хүндэт медалиар ирсэн зочид, ахмад дайчдыг 100 жилийн ойн медаль, ангийн 50 жилийн ойн медалиар шагналаа.

Мөн гавьяаныхаа амралтад гарсан 14 ахмад дайчин байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээ болж ангийн эмэгтэйчүүд ийн зөвлөлөөс санаачлан ангийн эмэгтэйчүүд гавьяаныхаа амралтад гарсан эмэгтэй ахмад дайчдад хүндэтгэл үзүүлж гарын бэлэг гардууллаа.

Орчин цагийн зэвсэгт хүчин байгуулагдсаны 100 жил, Монгол Улсад Нисэх хүчин хөгжсөний 96 жилийн ойн баярыг Зэвсэгт Хүчний 337 дугаар анги 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдөр тэмдэглэн өнгөрүүллээ. Баярын үйл ажиллагаанд хүндэт

зочноор Зэвсэгт Хүчний Агаарын цэргийн командлагч, хошууч генерал О.Энхбаяр, Агаарын цэргийн командлалын удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга хурандаа Б.Энхзоргол, Агаарын цэргийн командлалын Улсын нисэхийн хэлтсийн дарга хурандаа

“БОСОО БИЧИГ-БИДНИЙ БАХАРХАЛ”

Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл



Үндэсний хэл бичгийн өдрийг тохиолдуулан нэгтгэлийн нийт бие бүрэлдэхүүний дунд “Босоо бичиг-Бидний бахархал” монгол бичгийн сайхан бичигтэн шалгаруулах уралдааныг цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан нэгтгэлийн цахим сургалтын группээр дамжуулан цахимаар зохион байгуулж явууллаа.

Уралдаанд 100 гаруй хүн оролцсоноос мотобуудлагын батальоны хоёрдугаар ротын байлдагч У.Анхбаяр нэгдүгээр байр, ахлагч Ч.Одбаатар хоёрдугаар байр эзэлж өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ

100 ХҮҮХДЭД ГАРЫН БЭЛЭГ ГАРДУУЛАВ

Зэвсэгт хүчний 350 дугаар анги

“Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан жил бүрийн энэ өдөр бие бүрэлдэхүүнийхээ гэр бүл үр хүүхдүүдийг хүлээн авч олон тэмцээн уралдаан зохион байгуулж аав ээжийнхээ ажилтай танилцаж нэг өдрийг дурсамж дүүрэн өнгөрүүлдэг байсан бол энэ жил дэлхий нийтээр тархсан цар тахлын улмаас 0-2 насны 100 гаруй хүүхэд багачууддаа эрүүл энх сайн сайхныг хүсээд эцэг эхээр нь гарын бэлэг хүргүүллээ.



Д.ЛАХГАВДУЛАМ

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 100 ЖИЛИЙН ОЙН МЕДАЛИАР ЭНГЭРЭЭ МЯЛААЛАА

Говь-Алтай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Монгол Улсад орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ой, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан тус штабын офицерууд Төрийн одон медаль болон Зэвсэгт хүчний 100 жилийн ойн медалиар шагнагдсаныг аймгийн удирдлагууд “Олон улсын энхийг сахиулагчдын өдөр”-өөр гардууллаа.

Ахмад Г.МӨНХБАЯР

